

МОНГОЛЫН ХЯТАД СУДЛАЛЫН ХӨГЖИЛТ БА ХЯТАД СУДЛАЛЫН ИХ БАГШ Ч.ДАЛАЙ

Л.БЭГЗЖАВ*

Эртнээс эдүгээ хүртэлх Хятадын талын бүх асуудлыг тусгайлан судалдаг “ханьское” буюу “жунгоское” гэдэг шинжлэх ухааны бие даасан ухааныг дэлхий дахинаа хятад судлал гэж нэрлэдэг. Хятадыг судлах нь Европ, Ази, Америк тивд болон орон бүрд харилцан адилгүй, өөр өөр уламжлал, онцлогтой байдаг. Хятадаар ханьское, жунгоское гэж хоёр янзаар нэрлэдэг хятад судлал гэдэг нэр томъёо олон орны эрдэмтдийн дунд маргаантай асуудлын нэг юм. Энэ хоёр ойлголт нь адилгүй боловч нэгэн цогц, хооронд эрс ялгахын аргагүй ойлголт болно. Эрдэм боловсрол, мэдлэг оюуныг салгаж үздэггүй шиг хятадын судалгаа нь эцсийн дүндээ хоорондоо харилцан холбоотой. Европ дахинд хятад судлалыг “Sinology” гэж нэрлэдэг бөгөөд хятадын түүх, утга зохиол, хятад хэлийг голчлон судлах ухаан гэж үздэг. Хятад судлалыг хамгийн өргөн утгаар нь авч үзвэл Хятад улстай (“Жунго”) холбоотой аливаа судалгааны үр дүн, үйл явц юм. Хятад судлалын нэг чухал хэсэг бол хятадын дотоод газрын “хань бус үндэстэн”-ий түүх, хэл, соёл, шашин, ёс заншил, газар зүй зэрэг олон талын судалгаа юм. Ингэж үзвэл, хятад хэлний ханьское буюу sinology гэдгийг хятадын эрдэмтэд “орон судлал”-ын хүрээнд авч үздэг байна.

Өрнөдийн sinology гэдгийг япон хэлэнд ханьское гэж орчуулдаггүй, сина судлал гэж үздэг. Сүүлийн үед Америк, Европын эрдэмтэд ханьское буюу sinology гэдэг үгийг тун бага хэрэглэх болж, « жунго яньзю » буюу chinese studies гэх болов. Өөрөөр хэлбэл, ханьское гэдгийг хятад хэл, соёл судлал, жунгоское гэдгийг гадаад орон судлал гэдэг ойлголт тархсан ч өргөн утгаараа нэг л судалгааны хоёр тал, эцсийн дүндээ хятад судлал юм. Хятад судлал нь харилцан адилгүй түүхэн цаг хугацааны агуулгыг илтгэх төдийгүй хятадын соёл, дэлхийн соёлын нийлэх цэг юм. Хятадын судлал нь өөрөө их хувиралт, өөрчлөлтийн зам туулснаас гадна дэлхийн олон улс оронд хятадыг судлах хэрэгцээ шаардлага аль ч цаг үед байсан. Эндээс “дэлхийн хятад судлал” гэдэг томъёолол гарсан билээ.

* Л.Бэгзжав - Монголын хятад судлаачдын холбооны ерөнхийлөгч, доктор (Ph.D)

Дэлхийн хятад судлалын ухааны салшгүй нэг хэсэг нь монголын хятад судлал юм. Хятадтай олон мянган жил айл хөрш, хил залган оршиж ирсэн Монгол улс хятад судлалын эртний уламжлал, баялаг өвтэй дэлхийн цөөн орны нэгд зүй ёсоор орно. Монголын хятад судлал хоёр орны, хоёр ард түмний түүхэн харилцаатай салшгүй холбоотой өвөрмөц байдлаар хөгжиж иржээ. Өнгөрсөн түүхийг эргэн харвал, монгол орон дахь хятад судлалын үүсэл хөгжлийн түүх нь монголын түүхийн урсгалыг даган зарим үед тодорч, зарим үед бүдгэрэн, хөгжлийн урт зам туулжээ. Монголын хятад судлалын түүхэнд өөр өөрсдийн байр сууриа эзэлж, хүндтэй гавъяа байгуулсан эрдэмтэн мэргэд олон бий.

Эрдэмтэн Л.Түдэв гуайн хэлснээр XX зууны эхээр монголчууд авхаалж сэргэлэн үр хүүхдээ “оюуны таарцаг үүрүүлэн өрнийн Герман, Франц, Америк, өмнийн Хятад оронд илгээж, хожмоо алдартай болсон монгол залуус эрдэнэ номын эрдэнэс цуглуулж, эх орондоо эрдэм ухааны гэрэлт зул асаацгаасан юм” XX зууны II хагаст бас нэгэн шинэ үе эрдэм номын аянд мордож, өрнө, дорныг зорьсон билээ. Тэдний нэг нь шинэ Хятад улс байгуулагдсанаас хойш гуравхан жилийн дараа буюу одоогоос 48 жилийн өмнө БНХАУ-ын хамгийн том сургууль болох Бээжин их сургуульд суралцахаар очсон Ч.Далай байлаа. Ийнхүү БНХАУ-д анхны монгол оюутны нэг болж 6 жил суралцан төгсч түүхч болсон юм.

Монголын түүхийн анхдагч эх сурвалжууд бүгд хятад хэл дээр байдгийн хувьд хятад хэлтэй монголын түүхч төрөн гарсан нь монголын түүхчдийн шинэ үе төрөн гарахын эхлэл болжээ.

Ч.Далай багш сургуулиа төгсч ирээд МУИС-ийн түүхийн ангид хичээл зааж, ирээдүйн түүхчдийг бэлтгэх үйлсэд хүчин зүтгэсэн юм. Багшлах хугацаандаа хятад судлалын чиглэлээр олон бүтээл туурвисны дотор “Хятад хэлэн дээр байгаа Монголын түүхийн сурвалж бичгээс танилцуулах нь”, “Монголын түүхэнд холбогдол бүхий хятадын эртний тулгуур судар бичгээс танилцуулах нь” зэрэг хятадын түүхийн асуудлаар цуврал лекц бичсэн нь түүхч, түүх сонирхогчдын гарын авлага болж байв. Үүнээс гадна, “БНХАУ”, “Хятадын соёл, шинжлэх ухаан” гэсэн хоёр товхимол бичсэн байна.

Олон нийтийн үүсгэл санаачилгаар Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэг 1958 онд анх байгуулагдахад анхны нарийн бичгийн даргаар сонгогдсоноос хойш 40-өөд жил тус нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүнээр ажиллаж, хоёр орны найрамдлын үйлсэд хувь нэмрээ оруулсаар байна. БНХАУ байгуулагдсаны 10 жилийн ойд МХНН-ийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж БНХАУ-д айлчилсан байна.

1960-1962 онд хятад хэлээр гардаг “Ажилчны зам” сонины ерөнхий редактороор ажиллаж байсан бөгөөд энэ сонин түр завсарласны дараа дахин “Мэнгу сяоси бао” (“Монголын мэдээ”) нэрээр хэвлэгдэн гарч, монгол орныг хятад хэлээр дамжуулан гадаад ертөнцөд сурталчилж байна.

Тэрбээр хятад судлалаар мэргэжсэний хувьд 1962-1968 он хүртэл БНХАУ-д суугаа ЭСЯ-д нэгдүгээр нарийн бичгийн даргаар томилогдон дипломат алба хашжээ. Энэ бол Монгол-Хятадын харилцааны нэн төвөгтэй, хүнд бэрх үе байлаа. Хятад судлаач хүний хувьд Далай багшийн сурсан эрдэм ном энэ үед улс оронд нэн хэрэг болж байсан нь түүний цуглуулж судалсан олон тооны ном, сонин, материал, бичиж туурвисан олон арван өгүүлээс тодорхой харагддаг. Мөн хоёр дахь удаагийн дипломат томилолтоороо 1986-1989 онд дахиад л БНХАУ-д суугаа Монгол Улсын ЭСЯ-ны 1-р нарийн бичгийн даргаар ажилласан юм. Энэ үед Монгол-Хятадын өнөөгийн найрсаг харилцааны олон эхлэлийг тавихад Далай багш гар биеэрээ оролцсон юм. Хятадад ийнхүү 15 жил сурч, ажиллаж амьдрахдаа Хятад орны амьдралыг нэвтэрхий мэдэж, хятадын түүх, хятад судлалын талаар улсдаа тэргүүлэх эрдэмтэн болсон байна.

1960 онд дэлхийн хятад судлаачдын XII их хурал дээр « Монголын хятад судлалын байдал » гэсэн илтгэл тавьж энэ нь хятад хэлээр ном болон хэвлэгдэн гарсан нь Монголын хятад судлалын түүхэн уламжлал, хөгжлийг анх удаа нэгтгэн дүгнэж дэлхий дахинд танилцуулсан чамбай бүтээл болж, хожмын судлаачдын судалгааны чиг хандлагыг заан тодруулж өгсөн юм.

Академич Ч.Далай бол монголын нэрт түүхч төдийгүй хятадын түүхийн томоохон мэргэжилтэн яах аргагүй мөн билээ. Юань улсын түүх бол нэг талаар гарцаагүй монголын түүхийн нэг хэсэг боловч нөгөө талаар хятадын түүхийн нэг хэсэг мөн. Иймээс ч Юань улсын түүхийг нэвтэрхий судалж, хоёр орны түүхийг тодотгосон хүний нэг бол Далай багш гэдгийг “XIII зууны Монгол » гэдэг монгол, орос хэлээр гарсан номоор нь дэлхийн эрдэмтэд мэддэг билээ. Түүний бичсэн “Юань гүрний үеийн Монголын түүхийн зарим асуудал”, “Хубилай хаан ба түүний залгамжлагчдын хаан ширээ булаалдсан тэмцэл”, “Ар Юаны үеийн Монгол-Хятадын харилцааны асуудал”, “Юань ши”-гийн монгол орчуулга, “Хятад дахь Монголын нууц товчооны судлал” зэрэг хятад судлалын холбогдол бүхий олон арван өгүүлэл дэлхийн олон орны хэлээр орчуулагдан тарсан байна. Монгол-Хятадын харилцааны шинэ үеийн түүхийг бичсэн хүн бол мөн л Далай багш. Тэгээд ч “Монгол-Хятадын харилцаа” (1949-1984) гэсэн сэдвээр түүхийн

ухааны докторын зэргийг хамгаалсан юм.

Товчоор хэлбэл, Далай багш бол Хятадын түүхийн болоод Монгол-Хятадын харилцааны түүхийн амьд лавлах, монголын хятад судлалын их багш мөн. Үе үеийн хятад судлаачид академич Ч.Далай гуайг багшаа гэж хүндэтгэн биширч ирсэн бөгөөд олон олон шавь нарынхаа номын хуримыг мялаасан эрдэмтэн багш билээ. Тиймээс ч Далай гуайг монголын төдийгүй дэлхийн хятад судлаачид Да даши буюу буюу “Далай их багш” гэж хүндэтгэн дууддаг юм. Үүний нэгэн жишээ гэвэл 2000 оны 9-р сард хуралдсан “Зүүн Ази судлалын өнөөгийн байдал, хэтийн төлөв” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар хурал дээр энэ хүндэтгэлийг үнэхээр хүлээж чадсан том эрдэмтэн юм гэдгийг нүдээр харж, чихээр сонссон өчүүхэн шавь би багшаараа бахархаж баярлаж явсан сэтгэгдлээ та бүхэнтэй хуваалцахад нэн таатай байна.